



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/59

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтууд, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.1.5, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэргийн хохирогч Буяндэлгэр овогтой Буянхишиг 15 настай, ПЖ06232400 дугаарын регистртэй, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хууль эрх зүй, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд зардалд 1 000 000 төгрөг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 1 000 000 төгрөг /нэг сая/-ийг 2022 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 4.5-д заасан хөтөлбөр, төслийн арга хэмжээний зардлаас тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Н.Ганзориг)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ